

**Б.МӨНХБААТАР**

*Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Эрүүгийн
ял эдлүүлэх эрх зүйн
тэнхимийн багш,
ахлах дэслэгч*

ӨЛСГӨЛӨН ЗАРЛАСАН ХОРИГДОГЧИД ҮЗҮҮЛЭХ СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭНД АНХААРАХ АСУУДАЛ

Орчин үед сэтгэл судлалын шинжлэх ухаан нь 120 гаруй салбарт, судалгааны техник, технологи, онолын өргөн салбарт өргөжин тэлж байна. Үүнд шинжлэх ухаан, анагаах ухаан, бизнес, урлаг спорт, хууль цааз, гэх мэт нийгмийн олон салбарт эрчимтэй нэвтэрч үйл ажиллагаа явуулж байна. Олонхи шинжлэх ухаанд нэгэн ижил судлагдахуун болох “хүн” гэдэг судлагдахууныг тал бүрээс нь судалдагаараа нийтлэг боловч “ПЕНИТЕНЦИАР” сэтгэл судлалын судлах зүйл нь нийт хүмүүсийг гэхээс илүүтэйгээр хууль зөрчсөний улмаас Эрүүгийн ял шийтгэл хүлээн ял эдлэж байгаа болон тэдэнд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байгаа ажилтан, хамт олон, тусгай орчинд байгаа хүмүүсийн сэтгэхүйн үйл ажиллагааны механизм, зүй тогтлуудыг судлаж, нээн илрүүлэх үйл ажиллагаа явуулдагаараа онцлогтой юм.

Сэтгэл зүйн зөвлөгөө гэдэг нь үйлчлүүлэгчийн тавьж байгаа хүсэлт, эрэлт хэрэгцээ, асуудалд нийцүүлэн тодорхой арга техникийн

тусламжтайгаар явагддаг мэргэжлийн үйлчилгээний нэг хэлбэр юм. Энэхүү мэргэжлийн үйлчилгээг судлаачид /Сэтгэл зүйн онол-арга зүй, харилцааны дадал туршилагад тулгуурлан явагддаг мэргэжлийн үйлчилгээ. Тодорхойлж байгаа бэрхшээлээ бодитой ойлгои ухамсарлан ухаарч, өөрчлөлт хийх шийдвэр гаргахад нөлөөлөх өвөрмөц арга техник. Амьдралын хүнд байдал мухардлаас гарах хамтын ажиллагаа. Хувь хүний дотоод нөөц, чадавхийг нээн илрүүлэх, тэдгээрийг дайчлан идэвхижүүлэх, чадваржуулахад чиглэсэн сэдэлжүүлэх үйл явц гэж тодорхойлсон байдаг.

Сэтгэл зүйн зөвлөгөөний үе шат нь дараах байдлаар явагддаг байна.

- Сэтгэл зүйн харьцаа тогтоох үе шат
- Харилцан ойлголцох үе шат
- Өөрчлөлтийн үе шат

Сэтгэл зүйн зөвлөгөөг үндсэндээ гурав ангилан авч үзэх боломжтой юм:

1. Анхан шатны зөвлөгөө

/Анхан шатны зөвлөгөө гэдэг нь үйлчлүүлэгчид тохиолдсон асуудлын талаар шинжлэх ухааны үндэстэй мэдээлэл өгөх, тодорхой зөвлөмж санал болгоход гол зорилго нь чиглэгдэж байдаг/

2. Засал хавсарсан зөвлөгөө

/Хүмүүсийн алдаатай буруу, үзэл бодол, зан үйл, харилцаа хандлагад нөлөөлж, зөв шийдвэр гаргах, хүсэл эрмэлзэл, итгэл найдварыг төрүүлж сэдэлжүүлэхэд үйл ажиллагаа нь чиглэгдэж байдаг/

3. Сэтгэл засал

/сэтгэл засал нь засал хавсарсан зөвлөгөөтэй ижил төсөөтэй боловч шийдвэрлэх асуудлын зэргэмжээрээ,



үргэлжлэх хугацаа, явуулж байгаа орчин нөхцөл, түүнд тавигдах шаардлага зэргээрээ ялгаатай. Сэтгэл заслын үйлчилгээ нь эмнэлэгийн байгууллага дээр голлон явагддагаараа онцлогтой. Жишээ нь сэтгэцийн эмгэг харьцангуй өндөр үйлчлүүлэгчдийг хамааруулж ойлгож болно/.

Зөвөлгөөний үйл явцад төрөл бүрийн оношилгоо хийж, асуудлыг нарийвчлан тодруулах шаардлага зүй ёсоор тулгардаг. Энэ зорилгоор ажиглалт, тест, ярилцлага, тохиолдол жишээ, баримт мэдээлэлд задлан шинжлэл хийх зэрэг олон төрлийн аргуудыг ашигладаг. Хэрэв үйлчлүүлэгчид тохиолдсон асуудлыг үнэн бодитой, бүрэн дүүрэн оношилж чадвал түүнийг шийдвэрлэх үйл явц хурдан шуурхай явагдаж үр дүнд хүрнэ гэсэн үг.

Пенитенциар сэтгэл судлалын судлагдахууны нэг болох цагдан хорих байранд хоригдож байгаа хоригдогчид үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээ нь нөхцөл байдлын онцлогоос хамааран анхан шатны зөвлөгөө буюу хоригдогчид тохиолдсон асуудлын талаар тодорхой зөвлөмжийг өгөх ярилцлагын арга хэлбэрээр явагдах нь түгээмэл байдаг.

Өөрөөр хэлбэл орчин нөхцлөөс хамааран өнөөгийн практик ажил дээр цагдан хорих байранд ажиллаж байгаа сэтгэл зүйчдийн хувьд тодорхой хязгаарлагдмал цаг хугацааны туршид, сэтгэл зүйч үйлчлүүлэгч /хоригдогч/ хоёрын хооронд явагдах ярилцлага нь асуудлаа ухаарч ойлгох, одоогийн үзэл бодол, итгэл үнэмшилд нөлөөлөх, түүнийг шийдвэрлэх арга зам хувилбаруудыг боловсруулж хэлэлцэх, тэдгээрийг хэрэглэж туршихад цаг

хугацааны болон орчин нөхцлийн хувьд хязгаарлагдмал үйл ажиллагаа болон хувирсан байдаг.

Тиймд сэтгэл зүйн мэдлэгийг хэрэгжүүлэх явдал нь хорих байгууллагын үйл ажиллагаанд нэвтрэн хэрэгжиж байгаа нь сайн талтай боловч нөгөөтэйгүүр мэргэжлийн сэтгэл зүйчийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх орчин, нөхцөл хомс байгаа нь дутагдалтай тал байж болох юм.

Хоригдогчдийн өлсгөлөн зарлах гол шалтгааныг фокус бүлгийн ярилцлагын аргаар авагдсан судалгаанаас дүгнэж үзэхэд дийлэнх тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн эсэхээ тогтоолгохоор сэжиглэгдэн, хоригдсон үеэс эхлэн “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэргийн материалтай танилцуулахгүй байна, өөрийн зүйлчлэлээ хүлээн зөвшөөрөөгүй, ерөнхий байдлаараа хилс хэрэгт гүтгэгдэж байна, хэргийн байдлаа хурдан шийдүүлмээр байна, батлан даалтанд гарах буюу таслан сэргийлэх нөхцлөө өөрчилөх” гэх зэрэг шалтгааны улмаас өлсгөлөн зарласан тухай өргөдөл гаргах явдал практик ажил дээр дахин давталттайгаар гарсаар байгаа юм.

Шинээр буюу анх удаа цагдан хоригдож байгаа этгээдүүдийн ихэнх нь хорих анги, цагдан хорих байрны дотоод нөхцлийг буруугаар төсөөлөх, улмаар айж цочирдох явдал түгээмэл байдаг.

Зарим хоригдогчид “өлсгөлөн зарласнаар асуудлаа шийдүүлдэг” гэх бие биенээсээ ам дамжсан ташаа ойлголтоос, мөн мэдээлэл муутайгаасаа, нөгөөтэйгүүр тогтсон хандлага гэж хүлээн авч юун түрүүнд өлсгөлөн зарлахаа мэдэгдэж байгаа нь эцсийн



дүндээ өөрийнхөө бие эрэхтэндээ нөхөж баршгүй эрүүл мэндийн хор хохирол учруулж байгаа явдал юм.

Гэтэл Европын практик сэтгэл зүйчдийн нийтлэг стандартаас үзэхэд “Сэтгэл зүйн үйлчилгээ буюу сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйл явц нь үйлчлүүлэгчийн сайн дурын үндсэн дээр явагддаг бөгөөд хэрэв тухайн үйлчлүүлэгч, зөвлөгөө авахыг хүсэхгүй байгаа бол татгалзах эрхтэй. Харин тухайн үйлчлүүлэгч зөвлөгөө авах зайлшгүй шаардлагатай нөхцөлд байгаа бол энэ тухай ярьж тайлбарлан шийдвэр гаргахад нөлөөлж болно. Үйлчлүүлэгчийн амь нас эрүүл мэндэд аюул занал учирсан тохиолдолд түүний санал хүсэлтийг харгалзахгүйгээр зөвлөгөө тусламжийг цаг алдалгүй, түргэн шуурхай үзүүлэх шаардлагатай” гэж тусгасан байдаг байна.

Цагдан хорих байранд хоригдож буй хоригдогчид нь дийлэнх тохиолдолд сэтгэл санааны хувьд харьцангуй тогтворгүй байдаг нь нэг талаас нийгэмд чөлөөтэй явж байсан иргэнийг “Эрүүгийн байцаан шийтгэх” хуулийн дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хүрээнд нийгмээс тусгаарлан цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авагдаснаар чөлөөтэй байх эрхийг нь тодорхойгүй хугацаанд хязгаарлан цаашлаад хорих ял эдлэх санаа бодолгүй явсан этгээдийн хувьд үүнтэй холбоотой сэтгэцийн хариу үйлдэл болох сэтгэл зүйн хямрал, стресс үүсэх нь гарцаагүй юм.

Хоригдсон өдрөөс эхлэн сэжигтэн, хоригдогч нь сэтгэл зүйн асуудал бэрэхшээлд тулгардаг төдийгүй цаашид урт удаан хугацаанд хэрэг нь

шийдэгдэхгүй удах тусмаа дасан зохицох байдал бий болж камерт хоригдож байх хугацаандаа гэмт хэргийн ертөнцөд бие биенээсээ суралцах, нийгэмших бус шоронжих явдал бий болж болзошгүй юм.

Дүгнэлт

- Өлсгөлөн зарласан сэжигтэн, хоригдогчийн талаар хийгдсэн нэгдсэн судалгаа тоо баримт байдаггүй, өнөөгийн байдлаар хийгдсэн судалгаа нь зөвхөн хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны тоо бүртгэлийн тасагт сэжигтэн, хоригдогчийн зүгээс гаргасан өргөдөл гомдлын бүртгэл байдаг нь зөвхөн өргөдөл гаргасан этгээдийн шалтгаан нөхцлийн талаар судлах судлагдахуун мэдээ мэдээллээр хязгаарлагдаж байна. Цаашид сэтгэл зүйчдийн зүгээс хийгдэх судалгааны нэгдсэн цахим санг бий болгох шаардлагатай байна.
- Өлсгөлөн зарласан сэжигтэн, хоригдогчид үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний тодорхой арга зүй байдаггүй.

Санал зөвлөмж

- Өлсгөлөн зарласан этгээдтэй хэрхэн харьцах талаар алба хаагчдын дунд тогтмол хэлбэрээр сургалтыг зохион байгуулах;
- Өлсгөлөн зарласан этгээдтэй ажиллах эрх зүйн орчин нөхцлийг бий болгох;
- Өлсгөлөн зарласан этгээдтэй ажиллах сэтгэл зүйчийн орон тоог нэмэгдүүлэх, ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх;
- Нэн шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн орчинг бий болгох;

